

## БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

*Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.*

## ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

*Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.*

## ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



*Эрхэм оюутнууд аа, Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.*

*Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.*

*Хүн бүрдэд ажил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.*

*Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.*

**Б.ЦОГТМБАЯР**

## БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

*Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.*



## Валютын ханш

	АНУ доллар	1,984.69
	Евро	2,139.79
	Японы иен	16.52
	Швейцар франк	2,045.02
	Шведийн крон	229.96
	Английн фунт	2,932.97
	ОХУ-ын рубль	34.27
	БНХАУ-н юань	320.09
	БНСУ-ын вон	1.79
	Канадын доллар	1,561.09
	Малайзын ринггит	534.60
	Туркийн лира	759.59



## Хувь хүний орлогын албан татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?" асуулт хариултын тэмцээний танилцуулга

Үндэслэл: Татварын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Хамтын ажиллагааны гэрээний 2.2 дугаар заалт болох "Татвар төлөгчдийн татвараа өөрөө тодорхойлон төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлэх" ажлын хүрээнд жил бүр уламжлал болгон их, дээд сургуулиудад суралцагч оюутнуудын дунд "Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?" уралдааныг зохион байгуулж ирсэн. 2015 онд "Татвар төлөгч танд баярлалаа" уриан дор татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэх гэж байна.

Онцлог: Энэ удаагийн тэмцээнийг татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг эрхэлдэг, ТМЗ нийгэмлэгийн гишүүн "Төөгийтакс" ТМЗ ХХК-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна. Хамрах хүрээ нь татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр суралцагч их, дээд сургуулиудын дунд "Хувь хүний орлогын албан татварыг хэн сайн мэдэх вэ?" тэмцээнийг хоёр үе шатаар зохион байгуулна.

Нэгдүгээр үе шат: Энэ шатны тэмцээнийг дүүргийн татварын хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан ТУБ болон дүүргийн зохион байгуулах комисс удирдана. Зөвхөн дүүргийн хэмжээнд зохион байгуулна.

Хоёрдугаар үе шат: Хоёрдугаар шатны тэмцээнийг Татварын ерөнхий газар, ТМЗ нийгэмлэг, "Төөгийтакс" ТМЗ ХХК-ийн удирдлагын багаас бүрдсэн ерөнхий зохион байгуулах комисс

удирдана. Дүүргүүдээс шалгарсан шилдэг 6 баг оролцоно.

Болох хугацаа, байр: Эхний шатны тэмцээнийг дүүргийн Татварын хэлтэс 4 дүгээр сарын 30-ны дотор хариуцан зохион байгуулна. Хоёрдугаар шатны тэмцээн 5-р сарын 12-нд болно. Тэмцээн болох газрыг 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Материал хүлээн авах : Тэмцээнд оролцох багууд мэдүүлгээ харъяа дүүргийн татварын хэлтэст тэмцээн зохион байгуулах комисст хүргүүлнэ. Дүүргүүд шалгарсан багийн мэдүүлгийг Татварын алба, "ТМЗ" нийгэмлэгээс бүрдсэн зохион байгуулах комисст хүргүүлнэ.

Асуултын сан: Дүүрэг тус бүрийн зохион байгуулах комисс нь "Хувь хүний орлогын албан татварын хууль"-иар асуулт, хариултын сан боловсруулан дөрөвдүгээр сарын 10-ны дотор бичгээр болон файл хэлбэрээр комисст хүргүүлсэн байна.

Тэмцээний шагнал, урамшуулал:

1-р байр 500000 төгрөг, дурсгалын зүйл

2-р байр 300000 төгрөг, дурсгалын зүйл

3-р байр 200000 төгрөг, дурсгалын зүйл

• Багаа сайн зохион байгуулсан 1 багшийг урамшуулна.


Тэмцээний үйл явц, оролцоог татварын ерөнхий газрын [www.mta.mn](http://www.mta.mn), нийслэлийн татварын газар [www.nta.mn](http://www.nta.mn), ТМЗ нийгэмлэгийн [www.cpta.mn](http://www.cpta.mn) сайтад байршуулна.

## Нийлүүлэлтээс үүдэн зэсийн үнэ өслөө



Лондоны металлын бирж дэх зэсийн ханш гурван долоо хоног дараалан өслөө. Чилид үер болсноос үүдэн хамгийн том үйлдвэрлэгч "Codelco"-гийн нийлүүлэлт буурсан, уг таваарын томоохон хэрэглэгч Хятадын эрэлт нэмэгдсэн нь үүнд нөлөөлж буйг "Reuters" дамжууллаа. Бас Индонез дэх Грасберг уурхайн ажилчид ажил хаялт зарласан аж. Тус уурхай нь хүчин чадлаараа дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгддэг юм. Түүнчлэн

Перу дэх хоёр ч зэсийн уурхайн үйл ажиллагаа цаг агаараас болж зогсоод буй юм байна. "Энэ улиралд зарим уурхайн олборлолт түр зогсохоор байгаа нь зэсийн үнэд нөлөөлөх төлөвтэй байгаа" хэмээн Лондон дахь "Natix-is SA" компанийн ахлах шинжээч Ник Браун ярьжээ. Өнгөрсөн баасан гаригт Нью-Йоркийн "Comex"-т ирэх тавдугаар сард худалдан авах зэсийн үнэ 0.7 хувиар нэмэгдсэн байна. Мөн Лондоны металлын биржид гурван сарын дараа худалдан авах уг таваарын ханш 0.8 хувиар нэмэгдэж, тонн нь 6174 ам.доллартай тэнцлээ. Энэ сар гарсаар тэнд уг суурь металлын үнэ долоо гаруй хувиар өсөөд буй аж. Тус биржид хөнгөн цагаан, хар тугалга, цайрын үнэ мөн дээшилжээ. Саяханы нэг мэдээлэл сөхвөл зөвхөн "ӨМӨЗО-оос энэ оны 1-11-р сарыг хүртлэх нүүрс олборлолт нь өнгөрсөн жилийн мөн үеэсээ 109.83 сая тонн багасан, 11.6 хувьд хүрчээ. Энэ нь өнөө жилийн хувьд нүүрс олборолтыг дээд хэмжээнд багасгасан бөгөөд нүүрс олборлоход хоригтавих ажил үрдүнгээ өгч буйг харуулж байна" хэмээжээ. Тус мэдээллээс харахад л бүх зүйл ойлгомжтой харагдана.



## Япон улстай байгуулсан хэлэлцээр бидэнд ямар БОЛОМЖ болон СОРИЛТ АВЧРАХ ВЭ?

Өнөөдрийг хүртэлх хугацаанд манай улсаас Японд экспортолсон нийт барааны 57 хувь нь гаалийн 0 татвар, 10.9 хувь нь л тодорхой хэмжээний татвар төлдөг байжээ. Тэгэхээр бидэнд өмнө нь ч томоохон боломжууд байж. Мөн хэлэлцээрийг баталснаар Монгол Улс бүх үүдээ Япон бараанд цэлийтэл нээчихээгүй аж. Гадаад хэргийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал А.Ариунаа японы автомашинуудаар жишээ авч, манай улс насжилтаас нь хамааран харилцан адилгүй татвар тогтоосон гэсэн юм. Тодруулбал, цахилгаан хөдөлгүүртэй, байгаль орчинд ээлтэй, цоо шинэ машиныг л импортын татвараас бүрэн чөлөөлжээ.

Гурван жил үргэлжилсэн хэлэлцээний явцад манай тал оёмол сүлжмэл эдлэлийн гаалийн татварыг хангалттай буулгаж чадсан. Үүнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болох хивс, ноосон хувцас зэрэг багтаж байгаа юм.

### ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР ЯЛГАА ЮУ ВЭ?

Чөлөөт худалдааны гэрээгээр зөвхөн бараа бүтээгдэхүүнийг чөлөөтэй нэвтрүүлэх асуудлыг зохицуулдаг бол ЭЗТХ нь илүү өргөн хүрээг хамарсан иж бүрэн хэлэлцээр юм.

Орон бүрийн онцлогоос хамааран хэлэлцээрийн агуулга өөр өөр. Япон улс Филиппинээс олон тооны сувилалчийг гэрээгээр түр ажиллуулах хүсэлтэй байсан тул энэ хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээрт Хувь хүний шилжилт хөдөлгөөн гэсэн бүлэг нэмжээ. Манай улстай байгуулсан хэлэлцээрт Монголын бизнесмэн Японы аль нэг хөрөнгө оруулагчтай урт хугацаагаар хамтран ажиллах гэрээ байгуулсан бол тухайн хүнд тэр хугацааны виз олгох асуудлыг багтаасан аж.

### ЭНЭ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

Дэлхийн худалдааны байгууллагын (ДХБ) гишүүн орнууд өөр хоорондоо ЭЗТХ байгуулах бүрэн эрхтэй байдаг байна. Манай улс энэ байгууллагын гишүүн атлаа ЭЗТХ байгуулаагүй цорын ганц улс хэмээн “цоллуулж” байв. Дэлхийн худалдааны байгууллагаас олгодог нэн тааламжтай нөхцөлөөс илүү сайн нөхцөлийг ЭЗТХ олгодог онцлогтой.

Энд зааснаар хоёр орон дийлэнх худалдааныхаа 90-ээс доошгүй хувийг 10 жилийн хугацаатай гаалийн тарифаас чөлөөлөх үүргийг харилцан хүлээдэг. Дийлэнх хувь гэхээр 90-ээс доошгүй хувь гэсэн ойлголт олон улсын хүрээнд нэгэнт тогтсон жишиг. Мөн энэ хугацаанд талууд бие биедээ нэмэлтээр шинэ хориг тавихгүй хэмээн тохиролцдог байна. Гэхдээ хорио цээр, гаалийн бүрдүүлэлт, хөрөнгө оруулалт, өрсөлдөөн зэрэг асуудлыг заавал хамруулдаг.

**ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМ ЭЗТХ-ЭЭС ЯЛГААТАЙ**  
Манай улсын зарим бараа бүтээгдэхүүн АНУ, ЕХ, Японд тодорхой хөнгөлөлттэй гардаг. ЕХ-нд 7200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн гаргах боломжийг өмнө нь бүрдүүлж байсан. Хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудад татвар, тарифын хөнгөлөлтийг тодорхой хугацаанд олгодог бөгөөд өргөн хүрээний хэлэлцээ биш юм. Гэтэл зарим хүмүүс ЭЗТХ-ийг хөнгөлөлтийн ерөнхий системтэй андуурч ойлгох нь элбэг байна.

### ЯМАР НӨХЦӨЛД ЭЗТХ БАЙГУУЛДАГ ВЭ?

Дэлхий даяар 2001 оноос хойш ЭЗТХ байгуулах үйл явц зогсонги байдалд оржээ. Харин сүүлийн жилүүдэд эрчимжсэн байна. Одоогоор дэлхий даяар нийт 500

хэлэлцээр байгуулжээ. Үүний 80 хувийг 2000 оноос хойш байгуулжээ. Бидний хувьд анхдагч улс болох Япон улс энэ хэлэлцээрийг 2002 оноос байгуулж эхэлсэн юм. АНУ, Япон, ЕХ-ны улсуудад ЭЗТХ-ийг бизнес эрхлэгчдийн шахалтаар байгуулж байжээ. Тэд гуравдагч орны зах зээлд нэвтрэх гэхэд тарифын болон тарифын бус саад тулгарсан тул ийм гэрээ хийхээр эрх баригчдадаа шахалт үзүүлсэн байдаг. АНУ-ын хувьд хамгийн том ЭЗТХ нь НАФТА буюу АНУ-Мексик-Канадын хооронд байгуулсан гэрээ юм.

Харин манай улсын хувьд байдал өөр буюу эрх баригчдын санаачилгаар хийсэн гэдгийг МУИС-ийн багш, эдийн засагч Н.Отгонсайхан онцлов.

### ЭЗТХ-ИЙГ БАЙГУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Тухайн улс ДХБ-ын гишүүн бол энэ хэлэлцээрийг байгуулах эрх нээлттэй.

ДХБ-ын Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн 24 дүгээр зүйл, ДХБ-ын Үйлчилгээ худалдааны ерөнхий хэлэлцээрийн 5 дугаар зүйл, 24 дүгээр зүйлд зааснаар хоёр орон дийлэнх худалдааныхаа 90-ээс доошгүй хувийг 10 жилийн хугацаатай гаалийн тарифаас чөлөөлөх үүргийг харилцан хүлээдэг. Дийлэнх хувь гэхээр 90-ээс доошгүй хувь гэсэн ойлголт олон улсын хүрээнд нэгэнт тогтсон жишиг. Мөн энэ хугацаанд талууд бие биедээ нэмэлтээр шинэ хориг тавихгүй хэмээн тохиролцдог байна. Гэхдээ хорио цээр, гаалийн бүрдүүлэлт, хөрөнгө оруулалт, өрсөлдөөн зэрэг асуудлыг заавал хамруулдаг. **ЯПОН УЛСТАЙ БАЙГУУЛСАН ЭЗТХ БИДНИЙ ХҮСЭН ХҮЛЭЭЖ БҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАЖ ЧАДАХ УУ?** ЭЗТХ-ийн хамгийн чухал чухал хэсэг нь Хөрөнгө оруулалтын бүлэг. Энэ бүлгийг оруулснаар хоёр орны хөрөнгө оруулагчдад эрх зүйн баталгаатай орчин бүрдүүлэхийг зорьжээ. ЭЗТХ-ийг байгуулснаар манай улсын 2001 онд Япон улстай хийсэн Хөрөнгө оруулалтын гэрээ хүчингүй болно. Энэ гэрээ үйлчилж байх үед хөрөнгө оруулалттай холбоотой маргаан их гардаг байсныг харгалзан Хөрөнгө оруулалтын бүлгийг дэлгэрэнгүй буюу олон заалттай байгуулсныг Хөрөнгө оруулалтын газрын мэргжилтэн Э.Соёл-Эрдэнэ онцолж байв. Ирэх хоёр жилд Японоос манайд оруулдаг хөрөнгө оруулалт 400 сая ам.доллар болж өснө хэмээн тооцоолж байна. Бусад улсын түүхийг харвал Япон-Филиппин улсууд ЭЗТХ байгуулснаас хоёр жилийн дараа л Филиппинд хийх хөрөнгө оруулалт өссөн байна. 1992 онд Япон-Сингапур улсууд ЭЗТХ-ыг хамгийн анх байгуулснаар Сингапурт оруулах Японы хөрөнгө оруулалт 60 хувиар өссөн бол Мексикт гурав дахин өссөн байх жишээтэй.

Одоогоор Япон улс манайд хөрөнгө оруулсан компанийнхаа тоогоор дөрөвдүгээрт ордог, томоохон хөрөнгө оруулагч. 1990 оноос хойш Японы 550 ААН үүдээ нээн, банк санхүү, аялал жуулчлал, худалдаа, нийтийн хоол, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллаж байна. 550 ААН гэдэг нь манайд үйл ажиллагаа явуулдаг гаднын нийт компанийн 91 хувь юм. Тэд нийт хөрөнгө оруулалтаараа манай улсад 12 дугаарт жагсаж, нийт хөрөнгө оруулалтын 1.46 хувийг эзэлж байна. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор аялал жуулчлал, технологи, аж үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулалт өсөх аж. Дашрамд хэлэхэд манай улс нийт 42 улстай Хөрөнгө оруулалтын, хоёр талын гэрээ байгуулж, 39 орноос нь хөрөнгө оруулалт татаж чаджээ. Мөн нийт хөрөнгө оруулалтын 82 хувь нь гэрээтэй улсуудаас ордог тул гэрээ байгуулах нь үр дүнтэй.





## ЭЗТХ-ИЙГ БАЙГУУЛСНААР БИД ГААЛИЙН АЛЬ ТАРИФАА ХЭРХЭН БУУРУУЛАХ ВЭ?

Энэ хэлэлцээрийг байгуулснаар манай улс гаалийн тарифыг 96 хувиар, Японы тал 100 хувь буулгах аж. Гэхдээ энэ нь бараа бүтээгдэхүүн бүрт харилцан адилгүй. Гаалийн тарифын хөнгөлөлтөд хамрагдах бараа бүтээгдэхүүнийг мэргэжилтнүүд тодорхой үсгээр тэмдэглэдэг юм байна.

А тэмдэглэгээтэй бараа бүтээгдэхүүний гаалийн тариф хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 0 болно.

В тэмдэглэгээтэй бараа бүтээгдэхүүний гаалийн татварын хувьд В3, В5, В7 гэсэн үе шатлалаар гаалийн тариф буурах аж.

С тэмдэглэгээтэй бараа бүтээгдэхүүний гаалийн тариф огт оорчлогдохгүй, хэвээр үлдэнэ.

С тэмдэглэгээтэй бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг хоёр орон тусгай зохицуулалтаар буюу тусгайлан хэлэлцэж тогтоодог.

## ЭЗТХ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТУУД

Тухайн улстай хэлэлцээр байгуулах бодит хэрэгцээгээ тодорхойлно.

Судалгаа хийх багийг томилно. Энэ баг тухайн улсын хөгжлийн стратегид ЭЗТХ ямар нөлөө үзүүлэх, хэлэлцээр байгуулснаар урт болон дунд хугацаанд ямар өөрчлөлтүүд гарах, эдийн засгийн тодорхой салбар тус бүрт үзүүлэх нөлөөллийг судлах үүрэг хүлээдэг байна. Манай улсын хувьд Гадаад хэргийн яам, ЭЗХЯ-ны захиалгаар МУИС, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Стратеги судлалын хүрээлэнгийн эрдэмтэд хамтарсан судалгааны багт ажилласан юм.

Судалгааны бодлогын зөвлөмж гарна.

Хамтарсан судалгааны баг хэлэлцээ хийх нь зөв гэсэн шийдвэрт хүрнэ.

Талууд хэлэлцээний агуулгыг хэлэлцэж эхэлнэ. Энэ нь хамгийн багадаа 3 сар үргэлжилдэг. Зарим улс орон агуулгаа тохиролцоогүйн улмаас хэлэлцээр нь 7-8 жил хойшилсон тохиолдол ч бий.

Хэлэлцээрийг эцэслэн хоёр тал гарын үсэг зурна. Монгол, Японы Ерөнхий сайд нар хэлэлцээрт гуравдугаар сарын 8-нд гарын үсэг зурсан юм.

Хоёр улсын парламентаар соёрхон батална. Манай улсын парламент хэлэлцээрийг ямар ч саадгүй баталсан. Харин Японы парламент ирэх сард батлахаар төлөвлөж байна. Ингэснээр ЭЗТХ шууд хэрэгжиж эхлэх юм.

## ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАГДСАН ЭХНИЙ ЖИЛД УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО 9.8 САЯ АМ.ДОЛЛАРААР БУУРНА

Олон улсын жишгийн дагуу бид Японы талтай тухайн оны худалдааны үнийн дүнгийн 90 гаруй хувийг импортын гаалийн тарифаас шууд болон 10 жилийн хугацаанд үе шаттай чөлөөлөхөөр тохиролцчихлоо. Ингэснээр

Монголын тал 97 бүлгийн 5700 орчим төрлийн бараа, Японы тал 97 бүлгийн 9300 орчим төрлийн барааны импортын гаалийн тарифыг бууруулна.

Японы ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Кондо Казүмаса ЭЗТХ-ийн үр дүнг “Бие биенээ нөхсөн эдийн засгийн харилцаатай болно” хэмээн

дүгнэсэн юм. Хэрэв бид ЭЗТХ-ийн бидэнд олгож буй боломжийг бүрэн ашиглаж чадвал дараах үр дүнг харах боломжтой.

Хэрэглэгчийн хувьд

Японы зах зээлд манай бараа бүтээгдэхүүн маш таатай нөхцөлөөр нэвтэрнэ.

Манай зах зээлд Японы өндөр техник технологи нэвтэрч, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Ингэснээр манай компаниудын өрсөлдөх чадвар дээшилнэ.

Цаашлаад бараа бүтээгдэхүүний үнэ буурна.

Макро түвшний хувьд

Эдийн засгийн зохистой бүтэц бий болно.

Гадаадын шуудхөрөнгө оруулалт өснө.

## ЭЗТХ БАЙГУУЛСНААР ҮҮСЧ БОЛОХ СӨРӨГ ТАЛУУД

Өнөөдрийг хүртэл бидний төдийлөн дурдаагүй нэг асуудал нь Япон улстай ЭЗТХ байгуулснаар үүсч болох сөрөг талууд юм. Ямар ч зүйл хоёр талтай байдаг тул бид одооноос эдгээрт бэлтгэлтэй байх ёстой. МУИС-ийн багш Н.Отгонсайханы хэлж байгаагаар дараах уршиг үүсч болзошгүй гэнэ.

Бид Япон улсын импортын бараанд ноогдуулж байсан гаалийн ихэнх татвараа тэглэнэ. Иймд төсвийн орлого буурах нь тодорхой. Ажлын хэсгийн тооцоогоор хэлэлцээр байгуулагдсан эхний жилд улсын төсвийн орлого 9.8 сая ам.доллараар буурна. Гэхдээ Японы хөрөнгө оруулалт нэмэгдэж, хоёр орны худалдааны эргэлт өссөнөөр 9.8 сая ам.долларыг нөхөх бололцоотой гэнэ.

Өрсөлдөх чадвар муутай салбарт дотоодын үйлдвэрлэл уналтад орж болзошгүй. Үүнээс үүдэн ажилгүйдэл өснө. Иймд дотоодын аж үйлдвэрлэлийг хамгаалах заалтуудыг Хөрөнгө оруулалтын хэсэгт багтаажээ. Үүнд Монголын талаас 18, Японы талаас 22 салбарыг нэрлэсэн байна. Ингэснээр гаднын хөрөнгө оруулагчид тухайн салбарт огт хөрөнгө хийхгүй гэсэн үг биш. Харин дурдсан салбаруудад хөрөнгө оруулах бол нэмэлт материал бүрдүүлэх зэрэг шаардлага тусгажээ.

Захиргааны зардал өснө. Жишээ нь гааль дээр зөвхөн Японоос оруулж ирж буй барааны гарал үүслийг шалгах тусгай журам шинэчлэн батлах гэх мэт бичиг цаасны бэлтгэл ажлууд хийх шаардлагатай.

Ямартаа ч дэлхийн чанар, стандартын баталгаа болсон Японы зах зээлийг Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн тун удахгүй зорих нь ээ. Сүү ХК цөцгийн тосоо арлын оронд экспортлохоор боллоо гэх мэдээ саяхан гарсан.

Наран улсын иргэд Монголоос юуны өмнө эрүүл мэндийн шаардлага хангасан, ходоо аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой байна.

Бид та бүхэнд ЭЗТХ-ийг хэрхэн байгуулдаг болон хэлэлцээр байгуулснаар үүсч болох эерэг болон сул талуудыг танилцууллаа. Дараагийн нийтлэлдээ Япон руу экспортлох бидний гол нэрийн бараанд чацаргана нэмэгдэх үү, дээр дурдсан А болон В ангилалд багтсан буюу гаалийн тарифын хөнгөлөлтөд хамгийн түрүүнд багтсан бараанууд чухам юу вэ гэсэн асуултад хариулт өгөх нийтлэл хүргэх болно.



## Нийслэлд тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, автозам ашигласны төлбөр хураах ажлын тухай

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Авто зам ашигласны төлбөрийн хураах журмын хэрэгжилтийг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад албан татвар, төлбөрөө хуулийн хугацаанд төлөх нөхцөл бололцоог бүрдүүлэн өгч төрийн үйлчилгээг иргэдэд хүрч нэг цэгээс үзүүлэх, татвар төлөгчдийг шинэчлэн бүртгэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх үндсэн дээр нийслэлийн замын санг бүрдүүлэх зорилготой.

### Үндэслэл

Энэхүү арга хэмжээг Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Нийслэлийн засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 11 өдрийн А/128 тоот захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн А/143 тоот захирамжийн дагуу зохион байгуулж байна.

□ “Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 7 дугаар зүйл 7.1-д зааснаар иргэд автотээврийн хэрэгслийн албан татвараа жилд нэг удаа 6 дугаар сарын 1-ний дотор;

□ “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулийн 9 дүгээр зүйл 9.3-д төлбөр төлөгч нь Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албандаа төлөх;

□ Нийслэлийн засаг даргын 2015 оны А/128 тоот захирамжаар батлагдсан 3.3 нийслэлд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуй нэгж байгууллага нь нийслэлийн автозам ашигласны төлбөрийг тухайн жилийн 6 дугаар сарын 10-ны дотор төлөхөөр зохицуулагдсан байна.

### Онцлог тал

НИТХ-ын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн №28 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл төлбөрийн тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх журам” батлагдсан.

1. Энэ журмын 3.4-т Автотээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг тээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлийн оронгийн тоогоор дараахь дарааллаар тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах: Үүнд:

- 1, 6 тоогоор төгссөн бол нэгдүгээр сард;
- 2, 7 тоогоор төгссөн бол хоёрдугаар сард;
- 3, 8 тоогоор төгссөн бол гуравдугаар сард;
- 4, 9 тоогоор төгссөн бол дөрөвдүгээр сард;
- 5, 0 тоогоор төгссөн бол тавдугаар сард тус тус төлөхөөр заасан.

Энэ оны хувьд 1, 6, 2, 7-гоор төгссөн автотээврийн хэрэгсэл эзэмшигчид 2 дугаар сард багтаан албан татвар, төлбөрөө төлөх шаардлагатай.

2. Журмын 2-т автотээврийн хэрэгслийн бүртгэлийг боловсронгуй болгож Нийслэлд бүртгэлтэй идэвхитэй тээврийн хэрэгслийн нэгдсэн сан үүсгэх

Энэ ажлын хүрээнд автотээврийн хэрэгслийн бааз цэгцлэх ажлыг зохион байгуулж, эвдэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасах үйл ажиллагааг хялбаршуулсан байдлаар хийнэ.

3. “Smartcar” мэдээллийн системийн хэрэглээг өргөжүүлж, албан татвар, төлбөрийг онлайн, интернэт, мобайл банкаар шууд төлдөг тогтолцоонд шилжүүлэх, албан татвар, төлбөрийн орлогын төрөл тус бүрээр нэг данстай болж, орлогын мэдүүлгийг нэг загварт оруулах ажлыг арилжааны банкуудтай хамтран зохион байгуулна.

4. Автотээврийн хэрэгслийг албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр төлж, албан журмын даатгалд даатгуулсны дараа техникийн хяналтын үзлэгт хамруулан нэгдсэн нэг наалт олгох бөгөөд энэ наалт нь гаднаасаа уншигдах боломжтой чиптэй байна.

5. Гудамж замд суурилуулсан телекамерийн тусламжтайгаар тогтоосон хугацаанд албан татвар, төлбөрөө төлөөгүй, даатгал, оношлогоонд хамрагдаагүй автотээврийн хэрэгсэл эзэмшигчдийг илрүүлэн эзэмшигчийн бүртгэлийн хаягаар хууль тогтоомжинд заасан хувь хэмжээгээр торгууль ногдуулах ажлыг ЗХУТ зохион байгуулна.

### Албан татвар, төлбөр хураах ажлын зохион байгуулалт

Албан татвар, төлбөр хураах ажлыг төрийн үйлчилгээг татвар төлөгчдөд хөнгөн шуурхай хүргэх зарчмын дагуу нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж, нутаг дэвсгэрийн зарчмаар явуулна.

Иргэд, ААНБ, хуулийн этгээдүүд Улаанбаатар хотод бүртгэлтэй өөрийн нэр дээр байдаг хөдөө орон нутагт байгаа бүх төрлийн автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг харьяалах татварын албаны дансанд төлнө.

Импортоор оруулж ирсэн автотээврийн хэрэгсэлд шинээр улсын дугаар авахдаа, шилжилт хөдөлгөөн хийлгэхдээ албан татвар, төлбөрөө төлж, даатгал, оношлогоонд хамрагдсан байна.

“Нийслэлийн авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах журам” шинэчлэгдэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан гарсан. Хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй.

Албан татвар, төлбөрөө хуульд заасан хугацаанд төлөөгүй, албан журмын даатгалд даатгуулаагүй, техникийн үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгсэл эзэмшигчдэд Нийслэлийн Замын цагдаагийн газар хяналт тавьж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй, хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажиллана.

### Хугацаа

Албан татвар, төлбөр хураах ажлыг нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд:

- Албан татвар, төлбөр хураах ажлыг хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 31-ний хооронд;
- Хариуцлага тооцох хяналт шалгалтыг 2015 оны 6 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.